



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/157

Ховд

Тээврийн зардлын тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Засгийн газрын 2018 оны 218 дугаар тогтоолын 1 дүгээр заалт, аймгийн Онцгой комиссын 2019 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 6 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд хаваржилт хүндэрсэн сумдад олгохоор улсын нөөцөөс татсан 1000 ширхэг боодол өвс 82,2 тонн тэжээлийн тээврийн хөлсөнд 3500,0 төгрөг /Гурван сая таван зуун мянган/-ийг зарцуулсугай.

2. Тээврийн зардалд зарцуулах 3500,0 мянган төгрөгийг Засгийн газраас 2018 онд аймгуудын цаг үеийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхээр олгосон санхүүжилтийн үлдэгдлээс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /С.Гантөмөр/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Багдал/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Улсын нөөцөөс татан авч буй өвс, тэжээлийг хаваржилт хүндэрч буй сумдад хуваарилан хүргэх ажлыг шуурхай зохион байгуулахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ